



**ЭМГ-ЫН ДЭРГЭДЭХ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**


Орхон аймаг


2022. 06.17

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр				
1.1	Байгууллагын эцэг эхчүүдийн хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих талаар удирдлагатай хамтран ажиллах	Байгууллагын гэр бүл, хүүхдийн талаар дэлгэрэнгүй судалгааны ажил зохион байгуулах	Албан хаагчдын 100% хамрагдсан байна	ЭМГ-ын дэргэдэх эцэг эхийн зөвлөл нь байгууллагынхаа ажилчдын хүүхдийн талаар дэлгэрэнгүй судалгаа авч, шинэ ажилчид нэмэгдсэнтэй холбоотойгоор 2 удаа шинэчилсэн. Нийт 20 албан хаагчийн 37 хүүхэд байна. Үүнээс 26 нь эрэгтэй, 11 нь эмэгтэй хүүхэд байна. Судалгаагаар, 0-2 насны 6 хүүхэд буюу 16%, 3-5 насны 9 хүүхэд буюу 24%, 6-11 насны 15 хүүхэд буюу 40%, 12-13 насны хүүхэд байхгүй, 14-18 насны 7 хүүхэдтэй буюу 20%-ийг эзэлж байна. 0-18 насны хүүхэдтэй албан хаагчдын 85% нь орон сууцанд амьдардаг. 2 албан хаагч 4,5 давхарт амьдардаг, цонх нь хаалтгүй. Мөн 0-18 насны хүүхэдтэй албан хаагчдын 75% нь авто машинтай. Нийт албан хаагчдын 9,6% нь ургийн бичиг хөтөлдөг. ОУ-ын тэмцээн, уралдаанд оролцсон хүүхэд байхгүй. Нийт хүүхдүүдийн 27% нь зураг зурах, 16% нь спорт, 10% дуу хөгжим, 5% робот, леги, 5% ном унших, 5% түүх, мэтгэлцээн сонирхдог, үлдсэн 32% одоогоор тодорхойгүй байна.
		0-18 насны хүүхэдтэй гэр бүлийг дэмжих чиглэлээр албан хаагчдын дунд	Албан хаагчдын 100%	ЭМГ-ын 0-19 насны хүүхэдтэй гэр бүлийг дэмжих чиглэлээр албан хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлгийн үеэр “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” танхим сургалт, ЭМГ-ын



		ярилцлага хэлэлцүүлэг хийх, ажилтнуудын саналыг нээлттэй авах байдлаар зохион байгуулах	хамрагдсан байна	дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, санал хэлэлцүүлэг зохион байгуулагдсан ба ЭМГ-ын 0-18 насны хүүхэдтэй нийт 11 албан хаагч оролцсон. 
1.2	Гэр бүлийн харилцаа төлөвлөлт, гэр бүлийн үүргийн талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах	Залуу гэр бүлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгоор ахмад болон туршлагатай албан хаагчидтай хамтран бүлгийн ярилцлага зохион байгуулах	Сургалтад албан хаагчдын 80% доошгүй хувийг хамруулсан	НҮБ-ын ерөнхий ассамблей 1993 оны 05 сарын 20-ны хэлэлцээрээр 1994 оноос эхлэн 05 сарын 15-ны өдрийг "Гэр бүлийн өдөр" болгох тогтоол баталсан байдаг. "Гэр бүлийн өдөр"-ийг угтан Эрүүл мэндийн газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын дунд сургалт, нөлөөллийн арга хэмжээ, хэлэлцүүлэг, уралдаан гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдэвт сургалтыг зохион байгуулж ЭМГ-ын нийт албан хаагчид оролцлоо. Сургалтыг сэтгэл зүйч Э.Бямбасүрэн Г.Будмаа нар удирдсан. Залуу гэр бүлд гэр бүлийн үнэ цэнийн талаар ойлгуулах мөн зөвлөх зорилгоор урилгаар ЭМГ-ын зөвлөх Х.Уранчимэг эмч оролцож, хамтран бүлгийн ярилцлага зохион байгууллаа. Хэрэгжилт 100% 
		Тусгай хэрэгцээт боловсрол	Бөглөөрэй	ЭМГ-ын албан хаагчдын дунд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэдтэй эцэг эх байхгүй


		<p>шаардлагатай хүүхэдтэй албан хаагчдад сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх</p>		<p>бөгөөд дотоод цахим хаягаар дамжуулан тусгай хэрэгцээт боловсролын талаарх мэдлэгийг олгосон.</p> 
		<p>Бага болон балчир насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийг хэрхэн асрах талаар сургалт зохион байгуулах</p>	<p>0-5 насны хүүхэдтэй албан хаагчдын 80% доошгүй хувийг хамруулсан байна</p>	<p>Эрүүл мэндийн газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөл нь 0-5 нас буюу бага болон балчир насны хүүхдүүдтэй албан хаагчдын дунд тэдний сэтгэл зүйн онцлог болон бага насны хүүхдийн хоололтын талаар сургалтыг зохион байгуулж 9 албан хаагч оролцов. Сургалтын үеэр бага болон балчир насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог, насанд хүрэгсэд тэдэнтэй хэрхэн яаж зохистой харилцах талаар зөвлөмж, сэтгэл хөдлөл мэдрэмжийг илэрхийлэх “Котейка” картын тусламжтайгаар сэтгэл зүйн бүлгийн ярилцлага, бага насны хүүхдийн идэж болохгүй хүнс, илчлэг, хэмжээ, зөв хоололтын талаар хоол зүйчийн зөвлөмж, сургалт бүхий агуулгатай 2 цагийн арга хэмжээг зохион байгуулав. Хэрэгжилт 100%</p> 
1.3	Хүүхдийн нас бие,	Сургуулийн дунд		ЕБС-ын 14-р сургуулийн нийгмийн ажилтан

	<p>сэтгэхүйн онцлогийг таньж мэдэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулах</p>	<p>насны хүүхэдтэй албан хаагчдад тэдний сэтгэц онцлогийн талаар сургалт зохион байгуулах</p>	<p>Сургуулийн дунд насны хүүхэдтэй албан хаагчдын 80% доошгүй хувийг хамруулсан байна</p>	<p>Э.Мөнхтуул “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх”, “Хүүхдийн насны болон хувийн онцлог”, “Хүүхдэд учирч болох эрсдлүүд”, “Эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь” сэдвүүдээр албан хаагчдад сургалт орж мэдлэг олголоо .</p>
		<p>Өсвөр насны хүүхдүүдэд чиглэсэн мэргэжил сонгох ажил хөдөлмөрийн чиг баримжаа олгох, эцэг эхийн ажилладаг ажлын байр, ажлын онцлог, давуу талыг танилцуулах</p>	<p>Өсвөр настай хүүхэдтэй албан хаагчдын 80% доошгүй хувийг хамруулсан байна</p>	
		<p>Өсвөр насны хүүхдүүдэд чиглэсэн мэргэжил сонгох ажил хөдөлмөрийн чиг баримжаа олгох, эцэг эхийн ажилладаг ажлын байр, ажлын онцлог, давуу талыг танилцуулах</p>	<p>Өсвөр настай хүүхэдтэй албан хаагчдын 80% доошгүй хувийг хамруулсан байна</p>	<p>Хэрэгжих шатандаа явж байна.</p>
<p>2. Хүүхэд хүмүүжил, хөгжлийн чиглэлээр</p>				
<p>2.1</p>	<p>Албан хаагчдыг хүүхэдтэйгээ хамт чөлөөт цагийг</p>	<p>Олон улсын Эх үрсийн баярыг тохиолдуулан хүүхдийн бэлэг өгөх,</p>	<p>Хүүхэдтэй албан хаагчдыг 100%-иас доошгүй</p>	<p>Олон улсын эх үрсийн баярыг тохиолдуулан ЭМГ-ын нийт 33 албан хаагчдад эцэг эхийн зөвлөл, ЭМГ-ын даргатай хамтран ажиллах гэрээний 2.6 дугаар</p>


<p>өнгөрүүлэх боломжыг бүрдүүлэх</p>	<p>урамшуулах</p>	<p>хувийг хамруулсан байна</p>	<p>заалтанд тусгагдсан заалтын хүрээнд хүүхдийн баярын бэлэг олгосон.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p> 
	<p>Гэр бүлийн дунд хамтарсан уралдаан зохиох, эрүүл зөв зан үйлтэй гэр бүлийг бий болгоход санаачлага гаргах</p>	<p>Хүүхэдтэй албан хаагчдыг 100%-иас доошгүй хувийг хамруулсан байна.</p>	<p>Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан Эрүүл мэндийн газрын Эцэг эхийн зөвлөлөөс байгууллагын албан хаагчдын дунд “ЗӨВ ГЭР БҮЛ - ЗӨВ ДАДАЛ” цахим бичлэгийн уралдаан зохион байгууллаа. Гэр бүлийнхээ хүрээнд эрхэмлэдэг, амьдралдаа дадаж хэвшсэн эрүүл амьдралын хэв маяг, зөв дадлаа цахимаар дамжуулан сурталчлах, бусдад үлгэр дуурайлал үзүүлэх, ажлын хамт олондоо эерэг хандлагыг түгээх зорилготой тус цахим уралдааныг зохион байгуулсан юм.</p> <p>“ЗӨВ ГЭР БҮЛ -ЗӨВ ДАДАЛ” цахим бичлэгийн уралдаанд</p> <p>1-р байранд ЭМГ-ын УАУСЗТҮХБИАХА М.Бямбасүрэнгийн гэр бүл, 2-р байранд ЭМГ-ын бичиг хэрэг, даргын туслах ажилтан Н.Мөнх-Ундраагийн гэр бүл 3-р байранд ЭМГ-ын ЭМСММ Г.Итгэлийн гэр бүл тус тус шалгарч ӨРГӨМЖЛӨЛ гэр бүлийн бэлгийн багцаар шагнууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>

				
		<p>Хүүхдийн эрхийн тухай болон хүүхэд хамгааллын тухай хуулийг таниулах, сурталчилах</p>	<p>Сургалтанд албан хаагчдын 80%-иас доошгүй хувь нь хамрагдсан байна</p>	<p>Эрүүл мэндийн газрын Эцэг эхийн зөвлөлөөс байгууллагын хүүхэдтэй эцэг эхчүүдэд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр сургалт зохион байгуулж, 7 албан хаагч оролцлоо. Сургалтыг эцэг эхийн зөвлөлийн дарга удирдлаа.</p> <p>Энэхүү сургалтаар хүүхдийн эрхийн талаарх үндэсний хууль тогтоомжийг танилцуулж, хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл мөн хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар мэдлэг олголоо.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p> 
<p>Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр</p>				
		<p>Нийт албан хаагчдын утас таблетанд цахим хэрэглээг хязгаарлах заавар, эцэг эхийн хяналт хийх тохиргооны талаар сургалт зохион байгуулах, хяналт хийх программ, аппликешнг суулгах</p>	<p>Хүүхэдтэй Эцэг эхийн цахим хяналтын тохиргоог 100% хийсэн байна</p>	<p>Цахим орчинд түгээгдэж буй аливаа сөрөг мэдээлэл, түүний нөлөөллөөс бага болон өсвөр насны хүүхдийг хамгаалах зорилгоор Эрүүл мэндийн газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөл “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтыг ЭМГ-ын албан хаагчдын дунд зохион байгууллаа. Сургалтыг зөвлөлийн гишүүн П.Баярмаа, Г.Будмаа нар удирдсан бөгөөд бүх албан хаагчдад аюулгүй цахим хэрэглээний талаар танин мэдэхүйн зөвлөмж өгсөн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%.</p>

3.1	Албан хаагчдад хүүхийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, сургалтад хамруулах			
		Хүүхдийн тухай мэдээллийг зарлахгүй байх, цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийл чиглэлээр холбогд байгууллагад мэдэгдэх, хамтран ажиллах	Сургалтанд албан хаагчдын 80%-иас доошгүй хувь нь хамрагдсан байна	<p>ЭМГ-ын албан хаагчдын групп болон Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудсанд хүүхдийн мэдээллийг зарлахгүй байх тухай цахим зөвлөмж бэлтгэн нийт 5660 иргэнд хүргэсэн. Хэрэгжилт 100% тай.</p> 
		Сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөөг хүүхдийн тусламжийн 108 утсанд хандан авах талаар мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах	Албан хаагчдын 80%- иас доошгүй хувь нь мэдээлэлтэй болсон байна	<p>ЭМГ-ын албан хаагчдын групп болон Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудсанд хүүхдийн 108 утсанд хандан мэдээлэл авч байх тухай цахим зөвлөмж бэлтгэн нийт 3200 иргэнд хүргэсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100% .</p>

				
4.ЭМГ-ын ДАРГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ				
4.1	<p>Байгууллагын ажилтны тоо, цар хүрээ, боломжид тулгуурлан байгууллагын дэргэд хүүхдийн өдөр өнжүүлэх, албан хаагчдын амралтын өрөөг тохижуулах талаар дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Өрөөтэй болсон байна</p>	<p>Эрүүл мэндийн газар нь Захиргааны IV-р байранд байрладаг бөгөөд байгууллага нь өөрийн байргүй тул албан хаагчдын амралтын өрөөг хүүхдийн өрөөтэй хамт байгуулахаар төлөвлөсний үндсэн дээр 204 тоот өрөөг тохижуулан ажилчдын амралтын болон хүүхдийн өрөө болгосон. Уг амралтын өрөөг албан хаагчдын дотоод нөөц боломжийг ашиглан хүүхдийн өрөөний стандартын дагуу 11 ширхэг номтой, ном тус бүр картжуулсан номын булан, хүүхдийн тоглоом, шаардлагатай сандал ширээ байрлуулан, алын хаагчид болон хүүхдүүдийн аятай байдлыг хангахаар ус буцалгагч, шарах шүүгээ, зөөлөн буйданг байрлуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	
4.2	<p>Байгууллагын албан хаагчдын хүүхдийн төрсөн өдөр нь тохиож буй тухайн өдөр ажлын холбогдолтой сургалт, хурал гэх мэт цаг үеийн хойшлуулашгүй ажлаас бусад тохиолдолд ажлын хагас өдрийн цалинтай</p>	<p>-</p>	<p>ЭМГ-ын хувьд 36 албан хаагчдаас 0-18 насны хүүхэдтэй 21 албан хаагч байдаг бөгөөд сургууль болон цэцэрлэгийн насны хүүхэдтэй албан хаагчдыг хүүхдийн зайлшгүй тохиолдох аливаа асуудал, хүүхдийнх нь төрсөн өдөр тэмдэглэлт баярын үед хагас өдрийн цалинтай чөлөөг олгож уян хатан нөхцөлөөр ажиллах нөхцөлөөр бүрдүүлж</p>	

	<p>чөлөөг байгууллагын дарга тухайн ажилтантай зөвшилцсөнөөр олгож болно.</p>		<p>ажиллаж байна. Мөн нийт 0-18 насны хүүхэдтэй 22 албан хаагчдын бүх хүүхдийн судалгааг гаргасан бөгөөд үүнээс 37 хүүхдийн одоогийн байдлаар 08-р сарын сүүл хүртэл төрсөн нийт 22 хүүхдэд Эцэг эхийн зөвлөлийн зүгээс бичигт мэндчилгээ бүхий дурсгалын зүйлс өгч ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p> 
4.3	<p>Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулагдах санхүүжилтэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх.</p>	-	<p>2022 оны байдлаар эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд “Зөв гэр бүл- зөв дадал” цахим бичлэгийн уралдаан, Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Гэр бүлийн үнэ цэнэ” сэтгэл зүйн бүлгийн ярилцлага, асаргаа сувилгаа шаардлагатай байгаа хүүхэдтэй 1 албан хаагчийг Бүжинлхам сувилалд амраах, төрсөн өдөр нь тохиож буй албан хаагчдын хүүхдэд жижиг гарын бэлэг, Эх үрсийн баярыг тохиолдуулан 33 хүүхдийн гарын бэлэг</p>

			<p>болон албан хаагчдын тээврийн хэрэгсэл дээр наах наалт болон бусад сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг ЭМГ-ын даргатай хамтран ажиллах гэрээний 2.6 дугаар заалтыг үндэслэн 900.000 төгрөгний төсвийг хагас жилийн байдлаар гаргасан</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
4.4.	Сургуулийн бага ангийн болон цэцэрлэгийн насны хүүхэдтэй албан хаагчдад эцэг эхийн хуралд оролцох, эцэг эхийн эргүүл хийх боломжоор хангах	-	<p>ЭМГ-ын хувьд 36 албан хаагчдаас 0-18 насны хүүхэдтэй 21 албан хаагч байдаг бөгөөд сургууль болон цэцэрлэгийн насны хүүхэдтэй албан хаагчдыг эцэг эхийн хуралд оролцох, эцэг эхийн эргүүл хийх болон хүүхдийн зайлшгүй тохиолдох аливаа асуудал, хүүхдийнх нь тэмдэглэлт баярын үед 2 цагийн болон бүтэн өдрийн цалинтай чөлөөг олгож уян хатан нөхцөлөөр ажиллаж байна.</p>
4.5	Сайн дурын байгууллага болон тухайн байгууллага ажилтан, албан хаагчынхаа хүүхдүүдэд хандив тусламж өгөх, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дурын ажил зохион байгуулсан тохиолдолд хүүхдийн олон нийтийн өмнө онцгойлон нэрлэхээс татгалзах /амьдралын түвшин, бие, сэтгэхүйн өөрчлөлт зэргийг туслайлан онцлох/-оос татгалзах Хүүхдийн тухай мэдээллийг мэдээллийн хэрэгсэл, нийгмийн цахим сүлжээнд ил тод зарлахгүй байна.	-	<p>ЭМГ-ын албан хаагчдын групп болон Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудсанд хүүхдийн мэдээллийг зарлахгүй байх тухай, хүүхдийн насанд нь тохирсон хөдөлмөрт сургалт, тусгай хэрэгцээт боловсрол, сэтгэл зүйн онцлогт нь тохируулан харилцах гэх мэт 7 төрлийн 23 цахим зөвлөмж бэлтгэн нийт 12400 гаруй цахим тандалт авч, иргэнд хүргэсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100% .</p> 

4.6	Байгууллагын нэр хүндтэй үлгэр дуурайлал болсон гэр бүлийг сурталчилах, урамшуулах	-	<p>ЭМГ-ын дэргэдэх Эцэг эхийн зөвлөл нь эрүүл идэвхитэй амьдралыг эрхэмлэх зорилгоор “Зөв гэр бүл- зөв дадал” цахим бичлэгийн уралдааныг албан хаагчидын дунд зарлан нийт 7 бичлэг ирснээс 3 байрыг шалгаруулан 3 шагналт байр эзлүүлсэн. Олон улсын эх үрсийн баярыг тохиолдуулан ЭМГ-ын нийт 33 албан хаагчдад эцэг эхийн зөвлөл ЭМГ-ын даргатай хамтран ажиллах гэрээний 2.6 дугаар заалтанд тусгагдсан заалтын хүрээнд хүүхдийн баярын бэлэг олгосон.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
4.7	Цагдаагийн газар, ГБХЗХГ-тай хамтран ажиллана.	-	<p>Орхон аймгийн ГБХЗХГ-тай хамтран Дэлхийн гэр бүлийн өдрийн хүрээнд болон Засаг даргын Олон улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэх” А\538-р захирамжид үндэслэн –Бүх хайраа гэр бүлдээ сэтгэл зүйн өдөрлөг байгууллагаас хамтран зохион байгуулж, Гэр бүлийн чуулганд 2 албан хаагчийг гэр бүлийх нь хамт хамруулж, Эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж, Гэр бүлийн өдөрлөгт байгууллагын зүгээс хамтран оролцох гэх мэт олон ажлуудад хамтран болон үндсэн зохион байгуулагчаар ажиллаж байсан.</p> <p>Орхон аймгийн ЦГ-тай хамтран ЭМГ-ын албан хаагчдын тээврийн хэрэгсэлд “Хүүхэд зорчиж</p>

			байна” наалт наах , аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар зөвлөмж авч, хэрэгжүүлсэн. Хэрэгжилт 100%
--	--	--	---

Тайлан бичсэн : СЗТҮХА

Г.Будмаа